



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 СУУРЬ БОЛОВСРОЛ



ТҮҮХ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:

САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

- Дундад зууны үе хэддүгээр зуунаас эхэлсэн бэ?
 A. V зуун B. XV зуун C. XVIII зуун D. XXI зуун
- 1246 онд Тамир голын Шар ордонд болсон Их хуралдайгаар Өгөдэй хааны хөвүүн Гүюгийг Их Монгол улсын хаанаар өргөмжилжээ. Энэ үйл явдал хэддүгээр зуунд болсон бэ?
 A. XII зуун B. XIII зуун C. XIV зуун D. XI зуун

- Он тооллын шугамд тэмдэглэсэн онуудад ямар түүхэн үйл явдлууд болсон бэ?
 Он тооллын шугам:




- Тэмүжин мэндэлсэн, Чингис хаан Их Монгол улсыг байгуулсан.
 - Тэмүжин хаан болов, Наху гүнд Найманыг ялав.
 - Улз голд Татарыг довтолв, Далан нөмрөгт Татарыг довтолв.
 - Тэмүжин Мэргидийн довтолгоонд өртөв, Мау өндөрт Хэрэйдтэй байлдав.
- Чингис хаан зүүн гарын Харагун жидүн /Хянганы нуруу/-ий түмнийг хэнд захируулсан бэ?
 A. Наяа B. Боорчу C. Мухали D. Хорчи
 - Дараах сурвалжуудаас аль нь Монгол бичгээр бичигдсэн бэ?
 A. Судрын чуулган B. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх
 C. Чингисийн чулууны бичиг D. Юань улсын судар
 - Эдгээр аймаг улсуудаас загалмайн шашинтай нь аль вэ?
 A. Татар B. Мэргэд C. Монгол D. Онгуд

- Он тооллын шугамд тэмдэглэсэн онуудад ямар түүхэн үйл явдлууд болсон бэ?
 Он тооллын шугам:



- Зүчи нас барав, Зүчийн хүү Бат газар нутгийг нь захирах болов.
 - Дөргэнэ хатан төр барив, Өзбег хаан суув.
 - Тогтох хаан зоос гаргав, Алтан Орд улс задрав.
 - Бат хаан Оросын вангуудад харьяат хот улсаа захирах эрх олгов, Абдулла хаан өөрийн нэрээр гэрээг хийлгүүлэв.
- Их Юань улстай холбоотой үйл явдал аль вэ?
 A. 1260 онд Пагва лам улсын багшаар өргөмжлөгдөв.
 B. Ноёд, язгууртнууд Өзбег хааны үеэс Лалын шашинд оров.
 C. Кебек хаан улсдаа шинэчлэл хийв.
 D. Исмалайтыг довтоллон Багдадын халифт улсыг мөхөөв.

9. Ямар шашин Коран судрын сургаалыг баримталдаг вэ?
 А. Буддын шашин В. Лалын шашин С. Загалмайн шашин D. Хиндү шашин
10. Тан улсын үеийн Хятад хүмүүсийн баримтлан дагадаг сургаал аль вэ?
 А. Библийн судар В. Коран судар
 С. Күнзийн сургаал D. Их бага хөлгөний судар
11. Дундад зууны Японы Яматогийн улсыг юу гэж нэрлэдэг байсан бэ?
 А. Ниппон В. Тэнно С. Харакири D. Шинто
12. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичнэ үү.
 Тан улсыгонд жанжин байгуулжээ.
 А. 960, Жао Куанжин В. 626, Ли Ши Мин
 С. 755, Ан Лушан D. 618, Ли Юань
13. Уг томъёог ашиглаж, дасгалыг гүйцэтгээрэй. $(x=M-M/33+622)$
 Хижрийн тооллын 1200 он нь аргын хэдэн он болох вэ?
 А. 655 он В. 658 он С. 1786 он D. 1822 он
14. Одоогийн Мексик улсад орших Теночтитлан хотыг дундад зууны үед ямар хүмүүс барьж байгуулсан бэ?
 А. Ацтек В. Майя С. Энэтхэг D. Викинг
15. Хааны тушаалаар герцог, гүнгүүд цэрэгтэйгээ, тэдний тушаалаар баронууд цэрэгтэйгээ, харин бароны тушаалаар ямар хүмүүс дайнд ордог байсан бэ?
 А. Самурайнууд В. Рыцариуд С. Ацтекууд D. Санваартнууд
16. Константинополь хотыг яагаад “Алтан гүүр” гэж нэрлэх болов?
 А. Америк, Ази тивийг холбосон худалдааны гол хот болохоор
 В. Ази, Африк тивийг холбосон худалдааны гол хот болохоор
 С. Африк, Европ тивийг холбосон худалдааны гол хот болохоор
 D. Ази, Европ тивийг холбосон худалдааны гол хот болохоор
17. Бүдүүвчийг нөхөж бичнэ үү. Их Карл хааны үед Европын сургуулиуд Долоон Чөлөөт урлагаар хичээллэх болов.



- А. Биеийн тамир, Газарзүй В. Илтгэх урлаг, Хөгжим
 С. Улс төр, математик D. Гүн ухаан, Сансар судлал

18. 1054 онд Ромын Пап лам, Константинополийн патриархийн тэмцэл дээд цэгтээ хүрч, загалмайтны сүм Католик ба Үнэн алдартны сүм гэж хуваагдав. Энэ үйл явдал одоогоос хэдэн жилийн өмнө болсон ба хэддүгээр зуунд хамаарах вэ?
- A. 969 жилийн өмнө буюу X зуунд
B. 3077 жилийн өмнө буюу X зуунд
C. 969 жилийн өмнө буюу XI зуунд
D. 3077 жилийн өмнө буюу XI зуунд
19. Монголын нууц товчоонд Тэмүжинийг хаана төрсөн гэж бичсэн бэ?
- A. Хар зүрхний хөх нуур орчимд
B. Буйр нуурын орчимд
C. Хэрлэн мөрний хөдөө аралд
D. Онон мөрний Дэлүүн болдогт
20. Чингис хаан Алтан улсыг хэдэн онд анх довтолж ихэд ялсан бэ?
- A. 1211 он B. 1218 он C. 1219 он D. 1225 он
21. Гүюг хааныг Их Монгол улсын хаан ширээнд өргөмжлөх ёслол хэзээ, хаана болсон бэ?
- A. 1189 онд, Хар зүрхний Хөх нуурт
B. 1206 онд, Онон мөрний эхэнд
C. 1229 онд, Хэрлэн мөрний хөвөөнд
D. 1246 онд, Тамир голын шар ордонд
22. Түүх соёлын дурсгалт газар ямар үйл ажиллагаа явуулахыг хориглодог вэ?
- A. Судалгаа хийх
B. Сурталчлан таниулах
C. Сургалт шинжилгээ явуулах
D. Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах
23. 1229 онд Өгэдэй Их Монгол улсын хаан болов. Уг үйл явдал Чингисийн тооллын хэдэн онд болсон бэ?
- A. 68 онд B. 2391 онд C. 23 онд D. 2435 онд
24. 1251 онд Хэрлэний хөдөө аралд болсон Их хуралдайгаар Толуйн хөвүүн Мөнхийг Их Монгол улсын хаанд өргөмжлөв. Уг үйл явдал хэддүгээр мянганы хэддүгээр зуунд хамаарах вэ?
- A. НТ II мянганы XII зуунд
B. НТ I мянганы XIII зуунд
C. НТ II мянганы XIII зуунд
D. НТ I мянганы XII зуунд
25. 1271 онд Их Юань улсыг Толуйн хөвгүүн Хубилай байгуулжээ. Уг үйл явдал хэддүгээр жаран болон хэддүгээр зуунд хамаарах вэ?
- A. 4-р жаран, XII зуун
B. 4-р жаран, XIII зуун
C. 5-р жаран, XII зуун
D. 5-р жаран, XIII зуун